



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/46

Шивээговь сум

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2, Засгийн газрын 2018 оны 04 дүгээр тогтоол “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомж, батлагдсан дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон залуучуудын оролцоог дэмжих арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хагас, бүтэн жилээр аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлд тайлагнахыг зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Д.Сувд-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/32 дугаар “Залуучуудын салбар зөвлөл байгуулах тухай” захирамж, 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/17 дугаар “Сумын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажиллах журам батлах тухай” захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42121-448

Сумын Засаг даргын 2021 оны 05-р сарын 12-ны өдрийн 176 дугаар захирамжийн хавсралт



ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Тэргүүн:	П.Ганчимэг (Засаг дарга)
Дэд тэргүүн:	Ч.Сугармаа (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	Д.Сувд-Эрдэнэ (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүд:	Н.Амаржаргал (1 дүгээр багийн Засаг дарга) Э.Сувдмаа (Соёлын төвийн Биет бус өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн) Ө.Баяртөгс (Шивээ-Овоо хувьцаат компанийн ЭШ-25/90 алхагч экскаваторын туслах машинч) С.Банзрагч (Шивээ-Овоо хувьцаат компанийн диспитчер) С.Дэлгэрэх (Шивээ-Овоо хувьцаат компанийн Цахим мэдээллийн инженер) Б.Мөнхзул (Улаанбаатар төмөр замын Замын 3 дугаар анги Бригадын дарга) А.Даваасүрэн (Эрүүл мэндийн төвийн лаборант)

П.Дэлгэрбаяр

(Цагдаагийн хэсгийн төлөөлөгч)

Ж.Болор-Отгон

(3 дугаар сургуулийн багш)

В.Гэрэлтуяа

(Засаг даргын Тамгын газрын нярав)

Э.Халиун

(Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, эдийн засаг төлөвлөлт,
худалдан авах ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн)

О.Отгонбаяр

(Байгаль хамгаалагч)